



# АВТО МАШИН УГААЛГЫН ГАЗАРТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ


АРИУТГАХ ТАТУУРГЫН СҮЛЖЭЭНД НИЙЛҮҮЛЭХ  
ХАЯГДАЛ УС MNS6561:2024 СТАНДАРТ

Авто машин угаалгын газарт мөрдөгдөх стандарт

		Усны хэрэглээ	
Д/д	Үзүүлэлт	15 м3 их	240 м3 их
1	Усны орчин	6.0-9.0	
2	Умбуур бодис	400 мг/л	30 мг/л
3	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	200 мг/л	100 мг/л
4	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч	400 мг/л	100 мг/л
5	Бүх төрлийн угаагч бодис	10 мг/л	

УЛААНБААТАР ХОТ  
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР  
2026 ОН

## ЦЭВЭРЛЭСЭН УСАА ЭРГҮҮЛЭН АШИГЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СХЕМ (жишээ)



1. Трап 2. Элс, тос баригч 3. Тунгаагуур 4. Ус дахин цэвэрлэх төхөөрөмж  
5. Цэвэршүүлсэн хаягдал ус хүлээн авах сан 6. Лаг боловсруулах (хатаах)

## АВТО МАШИН УГААЛГЫН ГАЗРУУДАД МӨРДӨГДӨХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

**Зөвшөөрөл авах:** Усны тухай хуулийн 24.2, 28.4, 28.6 зааснаар хаягдал ус хаях, зайлуулах, ус ашиглах зөвшөөрлүүдийг авсан байна.

**Ус ашиглах гэрээ байгуулах:** Усны тухай хуулийн 29.1т зааснаар төвлөрсөн эх үүсвэрээс хангагдаж байгаа тохиолдолд Ус сувгийн удирдах газартай, төвлөрсөн бус эх үүсвэрээс усаар хангагдаж байгаа тохиолдолд нийслэлийн байгаль орчны алба, сум дүүргийн засаг даргатай “Ус ашиглах гэрээ”-г байгуулсан байна.

**Стандарт мөрдөн хэрэгжүүлэн ажиллах:** Усны тухай хуулийн 30.1.3. зааснаар хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны MNS 6561:2024 стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх.

**Төлбөр төлөх:** Усны тухай хуулийн 30.1.5. усны нөөц, ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх.


Гэрээг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх: Хот суурины ус хангамж, ашиглалтын тухай хуулийн 13 зүйлийн дагуу байгуулсан “Цэвэр усаар хангах, бохир ус татан зайлах гэрээ”-ний заалтыг мөрдөж ажиллана.

**Хүлээх хариуцлага:** Зөрчлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 3. "Бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл урьдчилан цэвэрлээгүй бохир усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, үйл ажиллагааг зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох гэсэн заалтын дагуу арга хэмжээ авахуулахаар санал гаргах.

Хангагч, эсхүл хэрэглэгч ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах.

Ус сувгийн удирдах газар 2026

## АВТО МАШИН УГААЛГЫН ГАЗАР СУУРИЛУУЛАХ АНХАН ШАТНЫ ТӨХӨӨРӨМЖ



Хэрэглээнээс гарсан бохир усыг цуглуулж, цэвэрлэгээний анхан шатны тоног төхөөрөмжид дамжуулах үүрэгтэй.

Усанд уусаагүй том хог хаягдлыг шүүж авах үүрэгтэй.

Бохир усанд уусаагүй элс, тосны нэгдлийг усны урсгалын нөлөөгөөр барих үүрэгтэй.

Бохир усанд уусаагүй лаг шавар, нарийн нэгдлийг тунгааж авах үүрэгтэй.

**Авто машин угаалгын газар нь хоногийн хэрэглээг болон гарч буй хаягдал бохир усны агууламжид үндэслэн анхан шатны тоног төхөөрөмжийн хэмжээг тохируулан суурилуулна.**

Ус сувгийн удирдах газар 2026